



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/61

Арвайхээр

Өвсний үнэ чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.а, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2020 оны “Хөрөнгө зарцуулах” тухай А/05 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1 Мал аж ахуйн 2019-2020 оны өвөлжилт, хаваржилт зарим сумдад хүндэрч болзошгүй, малчдын түвшинд бэлтгэсэн өвс, тэжээл дуусч, малын хоол тэжээлийн хомсдол үүссэн нөхцөл байдлыг харгалзан бүх сумдад буулгасан 23000 (хорин гурван мянга) боодол өвсний 219.500.000 (хоёр зуун арван есөн сая таван зуун мянга) төгрөгийн үнийг чөлөөлсүгэй.

2. Богд, Бат-Өлзий, Баянгол, Уянга, Сант, Баруунбаян-Улаан, Төгрөг, Гучин-Ус, Нарийнтээл, Хайрхандулаан сумдад 16000 (арван зургаан мянга) боодол өвсний ачаа тээврийн зардал 9.750.000 (есөн сая долоон зуун тавин мянга) төгрөгийг нэгдүгээр, сумдад үнэгүй олгох 23000 (хорин гурван мянга) боодол өвсний хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дээрх сумдад олгосон өвсний тээврийн зардлыг аймгийн гамшгаас хамгаалах эрсдлийг бууруулах арга хэжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100131

Аймгийн Засаг даргын 2020 оны ...  
дугаар сарын ... ны өдрийн ... дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт



ӨВС ТЭЭВЭРЛЭСЭН АЖ АХУЙН НЭГЖ, ИРГЭН

д/д	Сумын нэр	Буусан өвсний тоо	Тээврийн зардал нэг бүрийн үнэ /мянган төгрөг/	Тээврийн зардал /мянган төгрөг/	Аж ахуй нэгжийн нэр
1	Баруунбаян-Улаан	2000	2.0	2000.0	Далайгүүр ХХК
2	Төгрөг	2000	1.0	1000.0	Далайгүүр ХХК
3	Гучин-Ус	2000	1.0	1000.0	Далайгүүр ХХК
4	Нарийнтээл	2000	1.5	1500.0	Далайгүүр ХХК
5	Хайрхандулаан	2000	1.0	1000.0	Далайгүүр ХХК
6	Богд	1000	1.25	1250.0	ӨВ Баян борх ХХК
7	Баянгол	1000	0.5	500.0	ӨВ Баян борх ХХК
8	Уянга	1000	0.5	500.0	ӨВ Баян борх ХХК
9	Сант	1000	0.5	500.0	ӨВ Баян борх ХХК
10	Бат-Өлзий	1000	0.5	500.0	А.Эрдэнэбаатар
	НИЙТ			9750.0	

-оОо-

Аймгийн Засаг даргын 2020 оны 02  
дугаар сарын 19 ны өдрийн 001 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

СУМДАД ҮНЭГҮЙ ОЛГОХ ӨВСНИЙ ХУВААРЬ

д/д	Сумын нэр	Сумдад хүргэх өвсний тоо ширхэг	Өвс нийлүүлэх аж ахуй нэгжийн нэр
1	Нарийнтээл	2000	Далайгүүр ХХК
2	Хайрхандулаан	2000	Далайгүүр ХХК
3	Гучин-Ус	2000	Далайгүүр ХХК
4	Баруунбаян-Улаан	2000	Далайгүүр ХХК
5	Төгрөг	2000	Далайгүүр ХХК
6	Бүрд	1000	ӨВ Баян борх ХХК
7	Сант	1000	ӨВ Баян борх ХХК
8	Баянгол	1000	ӨВ Баян борх ХХК
9	Есөнзүйл	1000	ӨВ Баян борх ХХК
10	Өлзийт	1000	ӨВ Баян борх ХХК
11	Баян-Өндөр	1000	ӨВ Баян борх ХХК
12	Тарагт	1000	ӨВ Баян борх ХХК
13	Зүүнбаян-Улаан	1000	ӨВ Баян борх ХХК
14	Богд	1000	ӨВ Баян борх ХХК
15	Бат-Өлзий	1000	А.Эрдэнэбаатар
16	Хархорин	1000	ӨВ Баян борх ХХК
17	Хужирт	1000	А.Эрдэнэбаатар
18	Уянга	1000	ӨВ Баян борх ХХК
		23000	